

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны
114449... тоот албан бичгийн тавдугаар хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ



2025.12.12

Улаанбаатар хот

№	Зорилт /бодлогын үндэслэл/	Төсөл, арга хэмжээ	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2025 онд шаардлагатай хөрөнгө		Үндсэн хариуцагч	Хамтран хариуцагч	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая. төг/	Хэрэгжилт	Үнэлгээ
			Суурь түвшин	Зорилго т түвшин	Хөрөнгийн хэмжээ /сая. төг/	Эх үүсвэр					
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4.ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО											
Зорилго 4.1. Шинжлэх ухаан, технологи, инновац, хиймэл оюун ухааны салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.											
4.1.2.	МУХТЖҮЧ -5.3.2 ЗГҮАХ- 4.3.3.3	4.1.2.12. Улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт хамгаалалт, нууцлал аюулгүй байдлыг сайжруулах дэд бүтцийг бий болгох	80	100	742.0	Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн сайд	-	302.5	ТЕГ-аас 2024 оны 06 дугаар сард мэдээллийн аюулгүй байдлын аудит хийгдэж "Маш өндөр" түвшний эрсдэлтэй гэж дүгнэгдсэн. Эрсдэлийг бууруулах зорилгоор 2024.09.27-ны өдөр Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн төлөвлөгөөг нууцын түвшинд батлан, 2025 оны байдлаар 40 хувийн хэрэгжилттэй байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны "Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" А/45 дугаар тушаалаар Хяналт шалгалтын газрын дэргэд Кибер, аюулгүй байдлын хэлтсийг дарга 1, ахлах мэргэжилтэн 2, мэргэжилтэн 2 орон тоотой батлан, албан тушаалын тодорхойлолтын дагуу чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна. ТЕГ-аас 2024 онд хийсэн эрсдэлийн үнэлгээний зөвлөмжийн дагуу байгууллагын сүлжээний аюулгүй	100

[illegible]

										системийг байршуулсан бөгөөд серверийн физик суурилуулалт болон сүлжээний тохиргоог кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төвийн мэргэжилтнүүдтэй хамтран хийсэн. Тус систем нь байгууллагын дотоод сүлжээний урсгалыг тасралтгүй хянаж, сэжигтэй холболт болон халдлагын оролдлогыг илрүүлэх бөгөөд үүний дүнд эрсдэлийн түвшин буурч, мэдээллийн аюулгүй байдал сайжирсан. Эрчим хүчний аюулгүй байдал болон тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангах зорилгоор гэмтэлтэй 80 ширхэг тог баригчийн батарейт шинээр худалдан авч суурилуулсан. Мөн төвийн эрчим хүчний тэжээл тасарсан нөхцөлд Улсын бүртгэлийн ерөнхий газрын хоёрдугаар байрыг тасралтгүй цахилгаан хангамжаар хангахын тулд автомат горимоор ажилладаг CUMMINS C275 загварын, 250 kVA хүчин чадалтай дизель генераторт улирал бүр серверийн өрөө болон хэвлэх үйлдвэрийн хөрөгтийн төхөөрөмжид тогтмол үзлэг, үйлчилгээ хийж, шаардлагатай сервис ажлуудыг хугацаанд нь гүйцэтгэж байна. Иргэний бүртгэл, эд хөрөнгийн бүртгэл болон хүний нөөцийн системүүд нь зураг нөөцлөх боломжгүй нөхцөлд ажиллаж байна. Dell NX3230 сторежийн RAID контроллер гэмтэн шатсанаас үүдэн төхөөрөмжийн хэвийн ажиллагаа бүрэн доголдсон бөгөөд уг контроллерийг солих боломжийг судлахад энэ төрлийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 3	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

											жилийн өмнө зогссон дахин сэлбэг худалдан авах боломжгүй болсон байна. Тус сторейжийг 2014 оноос хойш ашиглаж ирсэн бөгөөд цаашид дахин ашиглах боломжгүй болсон ч түүн дээр байрлаж байсан мэдээллийг хуулан авах зорилгоор 2025.10.15-ны өдөр "Саммит компьютер" ХХК-аас шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч түр хугацаанд ажиллагаанд оруулж мэдээллийг хуулан авсан. "Цахим Монгол, төрийн шуурхай үйлчилгээ" зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр "Ухаалаг засаг 2" төслийг ЦХИХХЯ, Үндэсний дата төв хамтран хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд 2025-2027 онд бүртгэлийн системийн нөөц дата төвийг байгуулж, цахим үйлчилгээг тасралтгүй, найдвартай ажиллуулах дэд бүтцийг бүрдүүлж, мэдээллийн санг бэхжүүлэн, сервер тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчлэн, албан ёсны лицензтай программ хангамж ашиглан мэдээллийн болон сүлжээний аюулгүй байдлыг хангах юм. "Улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн сангуудыг нөөцлөх дата төвтэй болох" ажлын хүрээнд "Улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлал, аюулгүй байдлыг сайжруулах дэд бүтцийг бий болгох" худалдан авах ажиллагааны зар 2025.04.15-нд олон нийтэд нээлттэй зарлагдсан бөгөөд "Саммит Компьютер Технологи" ХХК хамгийн сайн санал ирүүлснээр гэрээ байгуулахаар ажиллаж байна.	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	---	--

							"Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн сервер, сүлжээ, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах" худалдан авалт хийгдсэн. "Смарт карт" ХХК-тай 2025.06.02-ны өдөр Н2025/27 дугаартай 55,000 (мян.төг) дүнтэй гэрээний байгуулсан. Тус ажлын хүрээнд иргэний үнэмлэх хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмжид засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн.	100
--	--	--	--	--	--	--	--	-----